



“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК

АЖ АХУЙН БОЛОН ЗАСВАРЫН БАГАЖ ХЭРЭГСЭЛ  
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

*Аж ахуйн болон засварын багаж хэрэгсэл  
нийлүүлэгчийг сонгох*

**ЭТТХК/20240202414**

## **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА**

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА.....	3
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ.....	10
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ.....	27
V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ.....	30

## I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

<b>A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>	
<b>1. Тендерийн цар хүрээ</b>	1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгт (цаашид “ӨХ” гэх)-д заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичгийг гаргаж байна. Зарлалын дугаар, тендер шалгаруулалтын нэр, дугаар, багцын мэдээлэл өгөгдлийн хүснэгтэд бичигдэнэ.
<b>2. Санхүүжилтийн эх үүсвэр</b>	2.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
<b>3. Худалдан авах ажиллагааны тогтоомж</b>	<p>3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.</p>
	3.3. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20 <sup>1</sup> , 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй.
<b>4. Оролцогч, сонирхогч этгээдэд тавигдах ерөнхий шаардлага</b>	<p>4.1. Оролцогч хуулийн 7.1.1-7.1.9-д заасан нөхцөлийг хангасан байна.</p> <p>4.2. Түншлэлээр оролцох тохиолдолд түншлэлийн гишүүн бүр ерөнхий шаардлага хангасан байна.</p> <p>4.3.. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.</p> <p>4.4. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.</p> <p>4.5. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.</p>
<b>5. Туслан гүйцэтгэгч</b>	<p>5.1. Хуулийн 6.4-т зааснаар тендерийн үнийн 20 хүртэл хувьтай тэнцэх гүйцэтгэлийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгэх үргийг гэрээнд заасан байна.</p> <p>5.2. Туслан гүйцэтгүүлэх хувь хэмжээ тендерийн үнийн 20 хувиас хэтэрсэн, эсхүл туслан гүйцэтгүүлэх тоо хэмжээг заагаагүй бол туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалzan үзэхгүй.</p> <p>5.3. Туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.</p>
<b>6. Бараанд тавигдах ерөнхий шаардлага</b>	6.1. Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан бараа худалдан авахаас,

		<p>эсхүл хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд оролцогч аль ч улсын гарал үүсэлтэй бараа санал болгож болно.</p> <p>6.2.Харьцуулалтын аргаар худалдан авах бараа Сангийн сайдын баталсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу хуулийн 4.1.25-д заасан цахим каталогид бүртгэгдсэн байна.</p>
<b>7.Худалдан ажиллагааны систем</b>	<b>авах цахим</b>	<p>7.1.Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.</p>
<b>Б.АГУУЛГА</b>		
<b>8.Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл</b>		<p>8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг дараах бүлэг болон түүний нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;</li> <li>II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;</li> <li>III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага, бараа нийлүүлэлтийн хуваарь;</li> <li>IV Бүлэг. Тендерийн жишиг маягт;</li> <li>V Бүлэг. Гэрээний нөхцөл.</li> </ul> <p>8.2.Тендер шалгаруулалтын зарлал, цахим системээр хүргүүлсэн урилга нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл болохгүй.</p> <p>8.3.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.</p>
<b>9.Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах</b>		<p>9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доoshгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.</p> <p>9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.</p> <p>9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.</p> <p>9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн тооцно.</p> <p>9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 10-д заасныг мөрдөнө.</p>
<b>10.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах</b>		<p>10.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.</p> <p>10.2.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.</p> <p>10.3.Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн</p>

	хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.
<b>11.Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт</b>	<p>11.1.Захиалагч сонирхогч этгээдийн тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>11.2.Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.</p> <p>11.3.Уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.</p>
<b>В.ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>12.Тендер шалгаруулалтын хэл</b>	<p>12.1.Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.</p> <p>12.2.Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.</p> <p>12.3.Хэрэв ТШЗ-ны 12.2-т заасан тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.</p> <p>12.4.Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.</p>
<b>13.Тендерийн бүрдэл</b>	<p>13.1.Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:</p> <p>13.1.1.ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;</p> <p>13.1.2.Тендерийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;</p> <p>13.1.3.ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;</p> <p>13.1.4.ТШЗ-ны 16-т заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.5.Бараа нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>13.1.6.Санал болгож буй бараа ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.7.ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;</p> <p>13.1.8.ТШЗ-ны 22.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;</p> <p>13.2.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.</p>

<b>14.Тендерийн жишиг маягт</b>	14.1.IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.
<b>15.Хувилбарт санал</b>	15.1. Хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг ирүүлэх шаардлагатай бол өгөгдлийн хүснэгтэд заана.
<b>16.Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг</b>	16.1.ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1. 16.2.Хэрэв өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 7.1-д заасан ерөнхий нөхцөлийг магадлахтай холбоотой баримт бичиг. 16.3.Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
<b>17.Чадавхын болон туршлагын шаардлага тавих үндэслэл</b>	17.1.ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тавихад хуулийн 15 дугаар зүйлийг баримтална. 17.2.Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй. 17.3.Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.. 17.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
<b>18.Санхүүгийн чадавхын шаардлага</b>	18.1.Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна. 18.2.Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 18.3.Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалzan үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй. 18.4.Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшхи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
<b>19.Техникийн чадавх болон туршлагын шаардлага</b>	19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна. 19.2.Техникийн болон туршлагын чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 19.3.Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

<p><b>20.Санал болгож буй бараанд тавигдах шаардлага</b></p>	<p>20.1.ТШЗ-ны 6.1-д заасан тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй. 20.2.Санал болгож буй барааны техникийн тодорхойлолтод нийцсэн болохыг нотлох баримтыг тендерт ирүүлнэ. 20.3.Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. 20.4.Хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй боловч шаардлага хангах болтуунд нотлох шаардлагатай.</p>
<p><b>21.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээ</b></p>	<p>21.1.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой өгөгдлийн хүснэгтэд заасан бол дараах баримт бичиг, мэдээллийг ирүүлнэ. Үүнд: 21.1.1.санал болгож буй барааг тасралтгүй, горимын дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд ашиглахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт, авах боломжтой хаяг, тэдгээрийн үнийн мэдээлэл; 21.1.2.засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл. 21.1.3.гадаадын этгээдийн хувьд нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт.</p>
<p><b>22.Тендерийн үнэ</b></p>	<p>22.1.Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна. 22.2.Тендерийн үнэ гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх эсэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. Өгөгдлийн хүснэгтэд тогтмол байхаар заасан тохиолдолд тохируулга хийх нөхцөлтэй тендер ирүүлсэн бол шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ. 22.3.Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарыг дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ. 22.4.Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно. 22.5.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.</p>
<p><b>23.Тендерийн валют</b></p>	<p>23.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай</p>

	хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлнэ.
<b>24.Тендер хүчинтэй байх хугацаа</b>	<p>24.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.</p> <p>24.2.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 24.1-д заасан хугацааг сунгаж болно.</p> <p>24.3.Оролцогч хугацааг сунгасан бол хуулийн 28.9-д зааснаар бичгээр мэдэгдэнэ.</p>
<b>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>	
<b>25.Тендер баталгаажуулах, илгээх</b>	<p>25.1.Тендерийг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулан илгээнэ.</p> <p>25.2.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.</p> <p>25.3.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> <p>25.4.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.3-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.</p>
<b>26.Тендер хүлээн авах эцсийн хугацаа</b>	26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
<b>Д.ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГАА</b>	
<b>27.Үнийн санал дуудах хугацаа</b>	<p>27.1.Хуулийн 34.6-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо зарлалд заасан шаардлагатай тоонд хүрсэн тохиолдолд уг ажиллагаа ТШЗ-ны 26.1-д товлосон хугацаанаас нэг цагийн дотор эхэлнэ.</p> <p>27.2.Үнийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу явагдана.</p> <p>27.3.ТШЗ-ны 27.2-т заасан ажиллагаа урилгад заасан хугацаанд үргэлжилж хаагдана.</p>
<b>28.Тендер нээх</b>	28.1.ТШЗ-ны 27.3-т зааснаар хугацаа хаагдахад цахим систем оролцогч нарын санал болгосон эцсийн үнийг өсөх дарааллаар эрэмбэлэх ба захиалагч зөвхөн эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг нээнэ.
<b>Е.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ/ХЯНАН ҮЗЭХ</b>	
<b>29.Тендерийг шаардлагад нийцэх эсэхийг хянан үзэх</b>	29.1.Нээсэн тендерийг хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн Сангийн сайдын баталсан зааврын дагуу хянан үзнэ.

	29.2.Тендерт ирүүлсэн аливаа баримт бичгийн үнэн зөв, хүчинтэй байдлыг шалгаж үзэх эрхтэй байна. 29.3.Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.
<b>30.Тендерийн талаар тодруулга авах</b>	30.1.Тендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.
<b>Ё.МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>31.Мэдэгдэл хүргүүлэх</b>	31.1.Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгднэ.
<b>32.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах</b>	32.1.Захиалагч ТШЗ-ны 8.1-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ. 32.2.Шалгарсан оролцогч ТШЗ-ны 32.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчийн тогтоосон хугацааны дотор хүргүүлнэ. 32.3.Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.
<b>Ж.БУСАД</b>	
<b>33.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах</b>	33.1.Захиалагч ТШЗ-ны 29.3-т зааснаар хянан үзээд бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зарлах эсэх мэдээллийг хуулийн 28.1.3-т заасан шийдвэрт заана. 33.2.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлахад хуулийн 34.11-д заасныг баримтална.
<b>34.Тендер шалгаруулалтад гомдол гаргах</b>	34.1.Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

## II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<b>ТШЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ</b>	<b>А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>									
<b>ТШЗ 1.1</b>	<b>Захиалагчийн нэр: “Эрдэнэс Тавантолгой” ХК</b>									
<b>ТШЗ 1.1</b>	<p>Зарлалын дугаар: <b>ЭТТХК/20240202414</b>      Тендер шалгаруулалтын нэр: <b>Аж ахуйн болон засварын багаж хэрэгсэл нийлүүлэгчийг сонгох</b>      Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр:</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="text-align: center; padding: 2px;">Багцын дугаар</th> <th style="text-align: center; padding: 2px;">Төсөл, арга хэмжээний нэр</th> <th style="text-align: center; padding: 2px;">Багцын дугаар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td style="text-align: center; padding: 2px;">Багц 1.</td> <td style="text-align: center; padding: 2px;">Аж ахуйн бараа материал, багаж хэрэгсэл</td> <td style="text-align: center; padding: 2px;">ЭТТХК/20240202414-1</td> </tr> <tr> <td style="text-align: center; padding: 2px;">Багц 2.</td> <td style="text-align: center; padding: 2px;">Засварын багаж хэрэгсэл</td> <td style="text-align: center; padding: 2px;">ЭТТХК/20240202414-2</td> </tr> </tbody> </table>	Багцын дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Багцын дугаар	Багц 1.	Аж ахуйн бараа материал, багаж хэрэгсэл	ЭТТХК/20240202414-1	Багц 2.	Засварын багаж хэрэгсэл	ЭТТХК/20240202414-2
Багцын дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Багцын дугаар								
Багц 1.	Аж ахуйн бараа материал, багаж хэрэгсэл	ЭТТХК/20240202414-1								
Багц 2.	Засварын багаж хэрэгсэл	ЭТТХК/20240202414-2								
<b>ТШЗ 2.1</b>	<p>Санхүүжилтийн эх үүсвэр: <b>Өөрийн хөрөнгө</b>      Нийт төсөвт өртөг: <b>48,494,983 /Дөчин найман сая дөрвөн зуун өрэн дөрвөн мянга есөн зуун наян гурав/ төгрөг</b></p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="text-align: center; padding: 2px;">Багцын дугаар</th> <th style="text-align: center; padding: 2px;">Төсөвт өртөг /төгрөг/</th> <th style="text-align: center; padding: 2px;">Төсөвт өртөг /үсгээр/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td style="text-align: center; padding: 2px;">Багц 1.</td> <td style="text-align: center; padding: 2px;">10,435,000</td> <td style="text-align: center; padding: 2px;">Арван сая дөрвөн зуун гучин таван мянга</td> </tr> <tr> <td style="text-align: center; padding: 2px;">Багц 2.</td> <td style="text-align: center; padding: 2px;">33,855,000</td> <td style="text-align: center; padding: 2px;">Гучин гурван сая найман зуун тавин таван мянга</td> </tr> </tbody> </table>	Багцын дугаар	Төсөвт өртөг /төгрөг/	Төсөвт өртөг /үсгээр/	Багц 1.	10,435,000	Арван сая дөрвөн зуун гучин таван мянга	Багц 2.	33,855,000	Гучин гурван сая найман зуун тавин таван мянга
Багцын дугаар	Төсөвт өртөг /төгрөг/	Төсөвт өртөг /үсгээр/								
Багц 1.	10,435,000	Арван сая дөрвөн зуун гучин таван мянга								
Багц 2.	33,855,000	Гучин гурван сая найман зуун тавин таван мянга								
<b>Б.АГУУЛГА</b>										
<b>ТШЗ 9.2</b>	<p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг:  <b>Хүлээн авагчийн нэр: “Эрдэнэс Тавантолгой” ХК</b>  <b>Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын-8, Финанс төв, 5-р давхар, 504 тоот, Улаанбаатар хот-15160, Монгол Улс</b>  <b>Утасны дугаар: 75055555 дотуур утас-504</b>      Сонирхогч этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас <b>ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө</b> захиалагчаас авах хүсэлтийг бичгээр <b>эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар</b> гаргаж болно.      Тендерийн баримт бичгийн тодруулга, нэмэлт мэдээлэлтэй холбогдуулан захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас <b>ажлын 2-оос доошгүй хоногийн өмнө</b> тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах эрхтэй ба энэ нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг байна.      Захиалагч тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр хүсэлтийг тодруулгын хамт албан бичгээр гаргаж Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлнэ. Ийнхүү нийтэлсэн даруйд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх сонирхогч этгээдүүдэд нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно.      Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэх үүрэгтэй.</p>									
<b>ТШЗ 11.1</b>	Тендер ирүүлэх өмнө уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>									
<b>В.ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>										

<b>ТШЗ 12.2</b>	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулгын хамт тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: “ <b>Зөвшөөрөхгүй</b> ”
<b>ТШЗ 16.2</b>	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг: “<b>Шаардана</b>”</p> <ol style="list-style-type: none"> <li>Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ээр дамжуулан шалгана.</li> <li>Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана.</li> <li>Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаарх хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ. Анхааруулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг тендер илгээх холбогдох хэсэг сонгож цахим хэлбэрээр ирүүлнэ. Түншлэлээр оролцож буй тохиолдолд түншлэлийн төлөөлөх эрх бүхий этгээд нь түншлэлийн гэрээг цахим системд баталгаажуулсны дараа гишүүн этгээдийн хүчин төгөлдөр тодорхойлолтыг тендер илгээх холбогдох хэсэгт сонгож илгээнэ.</li> </ol>
<b>ТШЗ 18.1</b>	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: “<b>Шаардана</b>”</p> <p><b>Борлуулалтын орлогын хэмжээ:</b> Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын хэмжээ нь тухайн багцын төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.</p> <p><b>Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ:</b> “Шаардахгүй”</p>
<b>ТШЗ 18.2</b>	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: “<b>Шаардана</b>”</p> <ol style="list-style-type: none"> <li>Санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</li> <li>Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг <a href="http://www.sainscore.mn">www.sainscore.mn</a>, <a href="http://www.burenscore.mn">www.burenscore.mn</a></li> </ol>

	хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг хянан үзэхэд харгалzan үзэхгүй.)
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлага: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li>Ажил гүйцэтгэх хүний нөөц: <b>“Шаардахгүй”</b></li> <li>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: <b>“Шаардахгүй”</b></li> <li>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: <b>“Шаардана”</b> Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 онуудын аль нэг жилд тухайн багцын төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлж ажилласан байх. <ul style="list-style-type: none"> <li>Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар,</li> <li>Гэрээ дүгнэсэн актын хуулбар эсхүл хүлээлгэж өгсөн актын хуулбар ирүүлэх</li> </ul> <b>Ижил төстэй бараанд:</b> Аж ахуйн бараа материал, багаж хэрэгсэл нийлүүлсэн туршлагыг тооцно.</li> <li>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: <b>“Шаардахгүй”</b>.</li> <li>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт шаардлага: <b>“Шаардана”</b></li> </ol>
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: <b>“Шаардана”</b></p> <ol style="list-style-type: none"> <li>Барааны үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлэх;</li> <li>Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх тухай албан мэдэгдлийг баталгаажуулж ирүүлэх;</li> <li>Захиалагчид нийлүүлэх бараа материал нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, шинэ, техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан байх шаардлагатай бөгөөд нийлүүлэх үед бараа бүтээгдэхүүнд гологдол гарсан тохиолдолд яяралтай шинээр сольж өгөх тухай албан мэдэгдлийг баталгаажуулж ирүүлнэ;</li> <li>Техникийн тодорхойлолтын шаардлага хангасан бараа материал нийлүүлэхийг баталгаажуулсан албан мэдэгдэл ирүүлэх;</li> </ol> <p>Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангагүй тохиолдолд тухайн тендерээс татгалзана. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай бөгөөд уншигдахгүй материалыг ирүүлээгүйд тооцно. ТӨХ-д шаардсан материалуудын аль нэг ирүүлээгүй, эсхүл өөрөөр ирүүлсэн тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТШЗ 19.3	Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ шаардлагатай эсэх: <b>“Шаардахгүй”</b>
ТШЗ 21.1	Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээний талаарх мэдээлэл ирүүлэх эсэх: <b>“Үгүй”</b> Санал болгож буй барааг тасралтгүй, горимын дагуу ашиглах хугацаа: <b>“Шаардахгүй”</b>

	<p>Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгатай холбоотой зааварчилгаа, мэдээлэл ирүүлэх эсэх: “Үгүй”</p> <p>Нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой бусад шаардлага: “Шаардахгүй”</p>
<b>ТШЗ 22.2</b>	Оролцогчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “ <b>Toхируулахгүй тогтолцол байна</b> ”
<b>ТШЗ 22.3</b>	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: “ <b>Тийм</b> ” <b>Incoterms 2020, DDP</b> “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Улаанбаатар хот дахь төв агуулах
<b>Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ</b>	
<b>ТШЗ 25.4</b>	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>Тендерт оролцогч нь Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ.</p> <p>Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг IV бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> <p>Бүх материалыг нууцалж ирүүлсэн тохиолдолд татгалзах үндэслэл болно.</p>
<b>ТШЗ 26.1</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь</p> <p><b>Огноо: 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдөр</b></p> <p><b>Цаг: 09 цаг 00 минут</b></p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.</p>
	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p><b>Огноо: 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдөр</b></p> <p><b>Цаг: 09 цаг 10 минут</b></p> <p>Тендер нээх газрын хаяг: “Эрдэнэс Таван толгой” ХК, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын-8 Финанс төв, 5-р давхар, 502 тоот, Улаанбаатар хот-15160, Монгол Улс</p>

## Техникийн тодорхойлолт

Санал болгох бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна. Хуулийн 26.8-д зааснаар эсхул түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэсэн техникийн тодорхойлолтод өөр бараа санал болгосон оролцогч техникийн тодорхойлолтод заасантай дүйцэх болохыг ТШЗ 20.2-т заасан баримт бичгээр нотолсон бол техникийн тодорхойлолтыг хангасан гэж үзнэ.



**Барааны нэр:** .....

<b>№</b>	<b>Захиалагчийн техникийн тодорхойлолт</b>  (Тухайн барааны үзүүлэлт тус бурийг дор жагсааж бичих ба хэрээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)	<b>Санал болгож буй техникийн тодорхойлолт</b>  (Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)	<b>Тайлбар</b> (дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилууллыг хавсаргана)
1			
2			
3			
...			

**[Үнэлгээний хороо худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн техникийн тодорхойлолтын жишиг нөхцөл, стандарт, загварыг баримтлан техникийн тодорхойлолтыг боловсруулна.]**

**БАГЦ 1- АЖ АХУЙН БАРАА МАТЕРИАЛ,  
БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

<b>№</b>	<b>Бараа, ажил, үйлчилгээ- ний нэр</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Тоо хэм- жээ</b>	<b>Зориулалт</b>	<b>Техникийн тодорхойлолт</b>	<b>Дүйцэх зураг</b>
1	Ажлын тэрэг	ширхэг	2	Газар шорооны ажилд	Сайн чанарын, хоёр дугуйтай, хоёр түрэгч гартай, 100л-с ихгүй багтаамжтай төмөр тэрэг	
2	Хүрз	ширхэг	40	Газар шорооны ажилд	1,5 метрээс багагүй төмөр эсхүл модон иштэй, төмрөөр хийгдсэн, дөрвөлжин хэлбэртэй, <b>3 кг</b> -с багагүй даацтай.	
3	Хүрз	ширхэг	30	Газар шорооны ажилд	1,5 метрээс багагүй төмөр эсхүл модон иштэй, төмрөөр хийгдсэн, дөрвөлжин хэлбэртэй, <b>5 кг</b> -с багагүй даацтай.	
4	Шүүр /талбай/	ширхэг	30	Гадаа талбайн цэвэрлэгээнд	Ногоон өнгийн хуванцар шүүр, модон эсвэл пластик иштэй байх,	
5	Хог түүгч хайч	ширхэг	20	Гадаа талбайн цэвэрлэгээнд	Сайн чанарын төмрөөр хийгдсэн 1 метрээс багагүй урттай.	
6	Савар	ширхэг	15	Гадаа талбайн цэвэрлэгээнд	Бүхэлдээ төмрөөр хийгдсэн, хөнгөн, 1,5 метрээс багагүй урттай байх.	
7	Цасны хүрз	ширхэг	50	Гадаа талбайн цэвэрлэгээнд	Хүйтэн нөхцөлд тэсвэртэй маш сайн чанарын, модон иштэй, дөрвөлжин хэлбэртэй хуванцар хүрз, 1.5 м-ээс багагүй урттай иштэй.	


8	Тармуур	ширхэг	30	Газар шорооны ажилд	13 см-с доошгүй өргөнтэй, 1.5 метрээс багагүй урттай, төмөр материалтай, модон иштэй байх.	
9	Мөс цохигч	ширхэг	40	Цас мөс цэвэрлэх	1,5 метрээс багагүй урттай модон, төмөр иштэй сайн чанарын, зузаан төмөр материалтай.	
10	Жоотуу	ширхэг	5	Газар шорооны ажилд	Зузаан төмөр материалтай, модон иштэй, 1 метрээс багагүй урттай.	
11	Лоом	ширхэг	10	Газар шорооны ажилд	Зузаан төмөр материалтай, 1.4 м-ээс багагүй урттай.	
12	Шүүр /тосгуур-тай/	Ширхэг	2	Өрөө тасалгаа болон гадна дотно цэвэрлэгээнд	Сайн чанарын хуванцар материалтай, зөвлөн үстэй, тосгуур нь өөр дээрээ самтай, 1 метрээс багагүй өндөртэй байх	
13	Цагаан хоолой	ширхэг	2	Дохиочны албан хэрэгцээнд	35 Ватт-с багагүй хүчин чадалтай, задгай талбайд 1200 метрээс багагүй цар хүрээнд тархах чадалтай, авч явахад 1 кг-с багагүй жинтэй, батарейтай байх	
14	Хөшиг /хуйлдаг/	ширхэг	12	Тээвэр, автозам хариуцсан албаны өрөө тасалгаанд	Бат бөх зузаан хулдаасан материалаар хийгдсэн. Хана таазанд тогтоох учир хөшиг тогтоогч бат бөх байх. Цагаан саарал болон цагаан өнгөтэй байх.	

					Гар ажиллагаагаар хааж нээдэг. Арчиж, цэвэрлэх боломжтой. 150x180см-4 ширхэг 98x100см-2 ширхэг 155x124см-1 ширхэг 148x118см-1 ширхэг 110x152см-1 ширхэг 120x110см-1 ширхэг 130x110см-1 ширхэг 210x110см-1 ширхэг	
--	--	--	--	--	--	--


## БАГЦ 2- ЗАСВАРЫН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Бараа, ажил, үйлчилгээ- ний нэр	Хэмжих нэгж	Тоо хэм- жээ	Техникийн тодорхойлолт	Зураг																																	
1	Түлхүүрийн цуглуулга	Багц	4	<p>Нэг цуглуулгадаа 5.5мм-34мм нийт 28 ширхэг түлхүүрээс бүрдэх ком түлхүүр</p>	 <p><b>ТҮЛХҮҮРИЙН ЦУГЛУУЛГА</b></p> <p>5.5 мм 6 мм 7 мм 8 мм 9 мм 10 мм 11 мм 12 мм 13 мм 14 мм 15 мм 16 мм 17 мм 18 мм 19 мм 20 мм 21 мм 22 мм 23 мм 24 мм 25 мм 26 мм 27 мм 28 мм 29 мм 30 мм 32 мм 34 мм эмжээтэн 28 ширхэгийн түлхүүрийн цуглуулга. Тогтолцой тал нь хүчиний жижд хувсиртал POWERDRIVE залтартай, 12 талт Стандарт: DIN 3113A/ISO 3318/7738 Материал: Хром - ванадий Хэлбэр: Ая болон ягшино нь 15° налуу.</p>																																	
2	Том Түлхүүр	багц	1	<p>Тус тус 36мм, 41мм, 46мм, 50мм, 55мм таван төрлийн ком түлхүүр</p>	 <p><b>WÜRTH</b></p> <p><b>1/2 ИНЧИЙН 6 ТАЛТ ДОРЦОВНЫ ЦУГЛУУЛГА</b></p> <p>Унадсан урс: 484,000 мян Тусган урс: 319,000 мян  Нийт 23ш: Тусган нийт Урзасын: 125мм Сонгуу замын 10,22 м кинжээтийн дарцас</p> <p>от.но: 098513 230 т. 7611 7940</p>																																	
3	1/2 Инчийн хайрцагтай дорцовны ком	Хайрцаг	4	<p>Техник засварт ашиглагдах нэг хайрцагтаа (10мм-32мм) хэмжээтэй 23 ширхэгтэй дорцовноос бүрдэх</p>	 <p><b>WÜRTH</b></p> <p><b>1/2 ИНЧИЙН 6 ТАЛТ ДОРЦОВНЫ ЦУГЛУУЛГА</b></p> <p>Хийн болон цахилгаан импакт хүчиний буунд хэрэглэгдэнэ. Нийт 12 ширхэгтэй 1/2 инчийн хүчиний дорцовны цуглуулга. 10-24мм хэмжээтэй 6 талт 10 ширхэг урт торцовнууд, 1 ширхэг уртасгагч болон 1 ширхэг согтуу залгаанаас бүрдэх</p>																																	
4	1/2 Инчийн урт хүчиний хайрцагтай дорцовны ком	Хайрцаг	1	<p>Хийн болон цахилгаан импакт хүчиний буунд хэрэглэгдэнэ. Нийт 12 ширхэгтэй 1/2 инчийн хүчиний дорцовны цуглуулга. 10-24мм хэмжээтэй 6 талт 10 ширхэг урт торцовнууд, 1 ширхэг уртасгагч болон 1 ширхэг согтуу залгаанаас бүрдэх</p>	 <p><b>1/2 ИНЧИЙН УРТ ХҮЧНИЙ ДОРЦОВНЫ ЦУГЛУУЛГА</b></p> <p>Хийн болон цахилгаан импакт хүчиний буунд хэрэглэгдэнэ. Нийт 12 ширхэгтэй 1/2 инчийн хүчиний торцовны цуглуулга. 10-24мм хэмжээтэй 6 талт 10 ширхэг урт торцовнууд, 1 ширхэг уртасгагч болон 1 ширхэг согтуу залгаанаас бүрдэх.</p> <table border="1"> <tr> <td>Баруун №:</td> <td>Урс</td> </tr> <tr> <td>0714900200</td> <td>583,000 мян</td> </tr> </table>	Баруун №:	Урс	0714900200	583,000 мян																													
Баруун №:	Урс																																					
0714900200	583,000 мян																																					
5	3/4 инчийн дорцов 6 талт	багц	1	<p>3/4 инчийн 6 талт дорцов (Тус бур нь: 27мм, 30мм, 32мм, 36мм, 41мм, 46мм, 50мм) 7 ширхэг богино загварын Wurth брэнд эсхүл түүнтэй дүйцэх стандарттай 6 талт дорцов</p>	 <p><b>3/4 ИНЧИЙН ДОРЦОВ 6 ТАЛТ</b></p> <p>Метрик, 6 талтай Годоруул: Никелевсан Затвор: бодино Стандарт: DIN 3124, ISO 2725, POWERDRIVE</p> <table border="1"> <tr> <td>Баруун №.</td> <td>Хэмжээ</td> <td>Үрс</td> </tr> <tr> <td>071514222</td> <td>SW22</td> <td>33,000 мян</td> </tr> <tr> <td>071514224</td> <td>SW24</td> <td>33,000 мян</td> </tr> <tr> <td>071514227</td> <td>SW27</td> <td>39,600 мян</td> </tr> <tr> <td>071514230</td> <td>SW30</td> <td>40,700 мян</td> </tr> <tr> <td>071514232</td> <td>SW32</td> <td>44,000 мян</td> </tr> <tr> <td>071514236</td> <td>SW36</td> <td>48,400 мян</td> </tr> <tr> <td>071514238</td> <td>SW38</td> <td>51,700 мян</td> </tr> <tr> <td>071514241</td> <td>SW41</td> <td>55,000 мян</td> </tr> <tr> <td>071514245</td> <td>SW46</td> <td>67,100 мян</td> </tr> <tr> <td>071514250</td> <td>SW50</td> <td>74,800 мян</td> </tr> </table>	Баруун №.	Хэмжээ	Үрс	071514222	SW22	33,000 мян	071514224	SW24	33,000 мян	071514227	SW27	39,600 мян	071514230	SW30	40,700 мян	071514232	SW32	44,000 мян	071514236	SW36	48,400 мян	071514238	SW38	51,700 мян	071514241	SW41	55,000 мян	071514245	SW46	67,100 мян	071514250	SW50	74,800 мян
Баруун №.	Хэмжээ	Үрс																																				
071514222	SW22	33,000 мян																																				
071514224	SW24	33,000 мян																																				
071514227	SW27	39,600 мян																																				
071514230	SW30	40,700 мян																																				
071514232	SW32	44,000 мян																																				
071514236	SW36	48,400 мян																																				
071514238	SW38	51,700 мян																																				
071514241	SW41	55,000 мян																																				
071514245	SW46	67,100 мян																																				
071514250	SW50	74,800 мян																																				

					<b>1 ИНЧИЙН ДОРЦОВ 12 ТАЛТАЙ</b>																																				
6	1 инчийн дорцов 12 талд	багц	1	1 инчийн 12 талт дорцов (Тус бүр нь: 36мм, 38мм, 41мм, 46мм, 50мм, 55мм, 60мм, 65мм, 70мм) богино загварын Wurth брэнд эсхүл түүнтэй дүйцэх стандарттай 12 талт дорцов	 <p>Метрийн замжээст, багино загвар Стандарт: DIN 3124, ISO 2725 Годоргүү: Хромжуулсан</p> <table border="1"> <thead> <tr> <th>Баруун №.</th> <th>Хэмжээ</th> <th>Үнд</th> </tr> </thead> <tbody> <tr><td>0714151136</td><td>36 мм</td><td>101,200 мтт</td></tr> <tr><td>0714151138</td><td>38 мм</td><td>107,800 мтт</td></tr> <tr><td>0714151141</td><td>41 мм</td><td>166,100 мтт</td></tr> <tr><td>0714151146</td><td>46 мм</td><td>174,900 мтт</td></tr> <tr><td>0714151150</td><td>50 мм</td><td>143,000 мтт</td></tr> <tr><td>0714151155</td><td>55 мм</td><td>176,000 мтт</td></tr> <tr><td>0714151160</td><td>60 мм</td><td>199,100 мтт</td></tr> <tr><td>0714151165</td><td>65 мм</td><td>243,100 мтт</td></tr> <tr><td>0714151170</td><td>70 мм</td><td>282,700 мтт</td></tr> <tr><td>0714151175</td><td>75 мм</td><td>205,700 мтт</td></tr> <tr><td>0714151180</td><td>80 мм</td><td>350,900 мтт</td></tr> </tbody> </table>	Баруун №.	Хэмжээ	Үнд	0714151136	36 мм	101,200 мтт	0714151138	38 мм	107,800 мтт	0714151141	41 мм	166,100 мтт	0714151146	46 мм	174,900 мтт	0714151150	50 мм	143,000 мтт	0714151155	55 мм	176,000 мтт	0714151160	60 мм	199,100 мтт	0714151165	65 мм	243,100 мтт	0714151170	70 мм	282,700 мтт	0714151175	75 мм	205,700 мтт	0714151180	80 мм	350,900 мтт
Баруун №.	Хэмжээ	Үнд																																							
0714151136	36 мм	101,200 мтт																																							
0714151138	38 мм	107,800 мтт																																							
0714151141	41 мм	166,100 мтт																																							
0714151146	46 мм	174,900 мтт																																							
0714151150	50 мм	143,000 мтт																																							
0714151155	55 мм	176,000 мтт																																							
0714151160	60 мм	199,100 мтт																																							
0714151165	65 мм	243,100 мтт																																							
0714151170	70 мм	282,700 мтт																																							
0714151175	75 мм	205,700 мтт																																							
0714151180	80 мм	350,900 мтт																																							
7	Дорцовны уртасгагч богино 3/4 оролттой	ширхэг	2	3/4 инчийн дорцовны уртасгагч богино 200мм	 <p>Стандарт: DIN 3123, ISO 3316 Годоргүү : Никелдсан</p> <table border="1"> <thead> <tr> <th>Баруун №.</th> <th>Нийт урт</th> <th>Үнд</th> </tr> </thead> <tbody> <tr><td>071514105</td><td>200 мм</td><td>77,000 мтт</td></tr> <tr><td>071514110</td><td>400 мм</td><td>70,400 мтт</td></tr> </tbody> </table>	Баруун №.	Нийт урт	Үнд	071514105	200 мм	77,000 мтт	071514110	400 мм	70,400 мтт																											
Баруун №.	Нийт урт	Үнд																																							
071514105	200 мм	77,000 мтт																																							
071514110	400 мм	70,400 мтт																																							
8	Дорцовны уртасгагч урт 3/4 оролттой	ширхэг	2	3/4 инчийн дорцовны уртасгагч урт 400мм	 <p>Стандарт: DIN 3123, ISO 3316 Годоргүү : Никелдсан</p> <table border="1"> <thead> <tr> <th>Баруун №.</th> <th>Нийт урт</th> <th>Үнд</th> </tr> </thead> <tbody> <tr><td>071514105</td><td>200 мм</td><td>77,000 мтт</td></tr> <tr><td>071514110</td><td>400 мм</td><td>70,400 мтт</td></tr> </tbody> </table>	Баруун №.	Нийт урт	Үнд	071514105	200 мм	77,000 мтт	071514110	400 мм	70,400 мтт																											
Баруун №.	Нийт урт	Үнд																																							
071514105	200 мм	77,000 мтт																																							
071514110	400 мм	70,400 мтт																																							
9	Дорцовны уртасгагч урт 1 инч оролттой	ширхэг	1	1 инчийн дорцовны уртасгагч урт 300мм	 <p>Цахилгаан болон хийн буунд хэрэглэхэд тохиомжтой. Стандарт: DIN 3121</p> <table border="1"> <thead> <tr> <th>Баруун №.</th> <th>Урт</th> <th>Үнд</th> </tr> </thead> <tbody> <tr><td>0714158607</td><td>175 мм</td><td>172,700 мтт</td></tr> <tr><td>071415201</td><td>300 мм</td><td>220,000 мтт</td></tr> </tbody> </table>	Баруун №.	Урт	Үнд	0714158607	175 мм	172,700 мтт	071415201	300 мм	220,000 мтт																											
Баруун №.	Урт	Үнд																																							
0714158607	175 мм	172,700 мтт																																							
071415201	300 мм	220,000 мтт																																							
10	Хатуу иш 3/4 оролттой	ширхэг	2	3/4 оролттой хатуу иш	 <p>Стандарт:DIN 3122, ISO 3315 Никель годоргүүтэй.</p> <table border="1"> <thead> <tr> <th>Баруун №.</th> <th>Нийт урт</th> <th>Үнд</th> </tr> </thead> <tbody> <tr><td>071514104</td><td>450 мм</td><td>132,000 мтт</td></tr> </tbody> </table>	Баруун №.	Нийт урт	Үнд	071514104	450 мм	132,000 мтт																														
Баруун №.	Нийт урт	Үнд																																							
071514104	450 мм	132,000 мтт																																							
11	Хатуу иш 1 инч оролттой	ширхэг	1	1 оролттой хатуу иш	 <p>1/4 ИНЧИЙН ХАТУУ ИШ</p> <table border="1"> <thead> <tr> <th colspan="3">1/4 ИНЧИЙН ХАТУУ ИШ</th> </tr> <tr> <th colspan="3">Хатуу иш 1 инч</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Төхөөрөмжлэлийн нийтээрээс</td> <td>Сошил - 1125, ISO 3315</td> <td>1/4" дулаачиний 24 зураг</td> </tr> <tr> <td>Баруун №.</td> <td>Нийт иш</td> <td>Үнд</td> </tr> <tr><td>071415008</td><td>300 см</td><td>183,700 мтт</td></tr> <tr><td>071415009</td><td>450 см</td><td>210,000 мтт</td></tr> <tr><td>071415010</td><td>600 см</td><td>240,000 мтт</td></tr> </tbody> </table>	1/4 ИНЧИЙН ХАТУУ ИШ			Хатуу иш 1 инч			Төхөөрөмжлэлийн нийтээрээс	Сошил - 1125, ISO 3315	1/4" дулаачиний 24 зураг	Баруун №.	Нийт иш	Үнд	071415008	300 см	183,700 мтт	071415009	450 см	210,000 мтт	071415010	600 см	240,000 мтт															
1/4 ИНЧИЙН ХАТУУ ИШ																																									
Хатуу иш 1 инч																																									
Төхөөрөмжлэлийн нийтээрээс	Сошил - 1125, ISO 3315	1/4" дулаачиний 24 зураг																																							
Баруун №.	Нийт иш	Үнд																																							
071415008	300 см	183,700 мтт																																							
071415009	450 см	210,000 мтт																																							
071415010	600 см	240,000 мтт																																							
12	Хэмжээст иш 1/2 оролттой	ширхэг	1	Боолтуудын чангалагтайг тохируулагч. 1/2 инчийн оролттой	 <p>1/2 ИНЧИЙН ХЭМЖЭЭСТ ИШ</p> <p>DIN EN ISO 4789:2003 стандартын залуу ± 3 % -ийн нормацештэй. Хийнгүй тохиоруулсан мөн хийбэрэн. Ажиллагааны цэвэрээс сертифицирээ. Хүчинчир нийцгээц.</p> <table border="1"> <thead> <tr> <th>Баруун №.</th> <th>Хувийн тохиоруулж залуу залуу</th> <th>Үнд</th> </tr> </thead> <tbody> <tr><td>07147122</td><td>20-100 Nm</td><td>550,000 мтт</td></tr> <tr><td>07147123</td><td>40-200 Nm</td><td>550,000 мтт</td></tr> <tr><td>07147124</td><td>60-300 Nm</td><td>660,000 мтт</td></tr> </tbody> </table>	Баруун №.	Хувийн тохиоруулж залуу залуу	Үнд	07147122	20-100 Nm	550,000 мтт	07147123	40-200 Nm	550,000 мтт	07147124	60-300 Nm	660,000 мтт																								
Баруун №.	Хувийн тохиоруулж залуу залуу	Үнд																																							
07147122	20-100 Nm	550,000 мтт																																							
07147123	40-200 Nm	550,000 мтт																																							
07147124	60-300 Nm	660,000 мтт																																							

13	Хэмжээст иш 3/4 оролттой	ширхэг	1	Боолтуудын чангалагтайг тохируулагч. 3/4 инчийн оролттой	<b>3/4 ИНЧИЙН ХЭМЖЭЭСТ ИШ</b>  DIN EN ISO 6789-2003 стандартын дагуу з 3 % -ийн нерийнээсээ. Олонд тогтолцоогаа маш хөгжлийн. Ажиллагаатайгоос сертификатыг. Хуванцар хөфгүүлэв. <table border="1"><thead><tr><th>Баргуны №.</th><th>Хувийн тохируулга зийн хэмжээ</th><th>Үз</th></tr></thead><tbody><tr><td>071471 25</td><td>300-1000 Nm</td><td>4,070,000 мянт</td></tr><tr><td>071471 26</td><td>110-550 Nm</td><td>2,915,000 мянт</td></tr></tbody></table>	Баргуны №.	Хувийн тохируулга зийн хэмжээ	Үз	071471 25	300-1000 Nm	4,070,000 мянт	071471 26	110-550 Nm	2,915,000 мянт
Баргуны №.	Хувийн тохируулга зийн хэмжээ	Үз												
071471 25	300-1000 Nm	4,070,000 мянт												
071471 26	110-550 Nm	2,915,000 мянт												
14	Адаптер буюу шилжүүлэгчийн сет	ширхэг	1	Хийн багаж ашиглахад шилжүүлэгч хийх Адаптер буюу шилжүүлэгчийн сет дотроо нийт 8 ширхэгтэй.	<b>АДАПТЕР БЮОУ ШИЛЖҮҮЛЭГЧИЙН СЕТ</b>  Нийт 8 ширхэгтэй, 6 socket wrench adapter - 3/4" c - 1/2", 1/2" c - 3/4" 1/2" c - 3/8" 2 bit adapter 1/4" - 1/4", 3/8" - 5/16" Art.-no: 096512 80      Үзэ: 220 <b>TX Түгэй түлхүүрийн цуглуулга</b> <ul style="list-style-type: none"><li>Никел гардруулж 8 ширхэгтэй TX түгэй түлхүүрийн цуглуулга.</li></ul>  <table border="1"><thead><tr><th>Баргуны №.</th><th>Түлхүүрийн хэмжээ</th><th>Үз</th></tr></thead><tbody><tr><td>071534 100</td><td>TX 9, 10, 15, 20, 25, 27, 30, 40</td><td>46,200 мянт</td></tr></tbody></table>	Баргуны №.	Түлхүүрийн хэмжээ	Үз	071534 100	TX 9, 10, 15, 20, 25, 27, 30, 40	46,200 мянт			
Баргуны №.	Түлхүүрийн хэмжээ	Үз												
071534 100	TX 9, 10, 15, 20, 25, 27, 30, 40	46,200 мянт												
15	Цэцгэн тусгай түлхүүр	багц	4	Цэцгэн, иж бүрэн, багц тусгай түлхүүрийн цуглуулга, хуванцар гэртэй	<b>ТУСГАЙ ТҮЛХҮҮРИЙН ЦҮГЛУУЛГА</b>  6 талт тусгай түлхүүрийн 9 ширхэгтэй урт зогворын цуглуулга, хуванцар гаргай, никел гардруулж. Хэмжээ: 1,5, 2, 2,5, 3, 4, 5, 6, 8, 10мм <table border="1"><thead><tr><th>Баргуны №.</th><th>Үз</th></tr></thead><tbody><tr><td>071531 120</td><td>66,000 мянт</td></tr></tbody></table>	Баргуны №.	Үз	071531 120	66,000 мянт					
Баргуны №.	Үз													
071531 120	66,000 мянт													
16	Тусгай түлхүүр цуглуулга	ширхэг	2	1,5мм-10мм хэмжээснүүдтэй 6 талт иж бүрэн багц тусгай түлхүүрийн цуглуулга, хуванцар гэртэй.	<b>ТУСГАЙ ТҮЛХҮҮРИЙН ЦҮГЛУУЛГА</b>  6 талт тусгай түлхүүрийн 9 ширхэгтэй урт зогворын цуглуулга, хуванцар гаргай, никел гардруулж. Хэмжээ: 1,5, 2, 2,5, 3, 4, 5, 6, 8, 10мм <table border="1"><thead><tr><th>Баргуны №.</th><th>Үз</th></tr></thead><tbody><tr><td>071531 120</td><td>66,000 мянт</td></tr></tbody></table>	Баргуны №.	Үз	071531 120	66,000 мянт					
Баргуны №.	Үз													
071531 120	66,000 мянт													
17	Гинжин эсхүл туузан шүүр тайлагч	ширхэг	2	76-172мм хэмжээстэй Гинжин эсхүл туузан шүүр тайлагч түлхүүр, төмөр бариултай, жижиг гинжтэй эсхүл өргөн туузан оосортой байх	<b>Лоомын цуглуулга</b>  Шүлүүн үзүүртэй 930мм урт, 30° үзүүртэй 920мм урт, 60° үзүүртэй 650мм урт болон 90° үзүүртэй 640мм талт 4 ширхэг лоомоос. Буранда. <table border="1"><thead><tr><th>Баргуны №.</th><th>Үз</th></tr></thead><tbody><tr><td>195200 1250</td><td>823,000 мянт</td></tr></tbody></table>	Баргуны №.	Үз	195200 1250	823,000 мянт					
Баргуны №.	Үз													
195200 1250	823,000 мянт													
18	Лоомын цуглуулга	ширхэг	1	Шулуун үзүүртэй 930мм урт, 30° үзүүртэй 920мм урт, 60° үзүүртэй 650мм урт болон 90° үзүүртэй 640мм талт 4 ширхэг лоомоос бүрдэнэ.	<b>Дутуй толгонт ох</b> <ul style="list-style-type: none"><li>Төмөр хүчтэй 70-170мм талт.</li><li>Fiberglass нийц.</li></ul>  <table border="1"><thead><tr><th>Баргуны №.</th><th>Жин</th><th>Үз</th></tr></thead><tbody><tr><td>69707</td><td>700 гр</td><td>132,000 мянт</td></tr><tr><td>69708</td><td>1000 гр</td><td>143,000 мянт</td></tr></tbody></table>	Баргуны №.	Жин	Үз	69707	700 гр	132,000 мянт	69708	1000 гр	143,000 мянт
Баргуны №.	Жин	Үз												
69707	700 гр	132,000 мянт												
69708	1000 гр	143,000 мянт												
19	Алх төмөр Жижиг	ширхэг	2	700гр-с багагүй жинтэй дугуй толгойт алх, Төмрийн хатуулаг 50-58HRC Fiberglass эсхүл түүнтэй дүйцэх иштэй	<b>Лантуу</b> <ul style="list-style-type: none"><li>Төмөр хүчтэй 50-58HRC.</li><li>Fiberglass нийц.</li></ul>  <table border="1"><thead><tr><th>Баргуны №.</th><th>Жин</th><th>Үз</th></tr></thead><tbody><tr><td>69707</td><td>700 гр</td><td>132,000 мянт</td></tr><tr><td>69708</td><td>1000 гр</td><td>143,000 мянт</td></tr></tbody></table>	Баргуны №.	Жин	Үз	69707	700 гр	132,000 мянт	69708	1000 гр	143,000 мянт
Баргуны №.	Жин	Үз												
69707	700 гр	132,000 мянт												
69708	1000 гр	143,000 мянт												
20	Алх төмөр лантуу	ширхэг	2	6кг-с ихгүй жинтэй Төмрийн хатуулаг 50-58HRC, Fiberglass эсхүл түүнтэй дүйцэх иштэй	<b>Лантуу</b> <ul style="list-style-type: none"><li>Төмөр хүчтэй 50-58HRC.</li><li>Fiberglass нийц.</li></ul>  <table border="1"><thead><tr><th>Баргуны №.</th><th>Жин</th><th>Үз</th></tr></thead><tbody><tr><td>69707</td><td>6 кг</td><td>312,000 мянт</td></tr></tbody></table>	Баргуны №.	Жин	Үз	69707	6 кг	312,000 мянт			
Баргуны №.	Жин	Үз												
69707	6 кг	312,000 мянт												

21	Резин алх	ширхэг	2	700гр-с багагүй жинтэй 40мм-ийн диаметртэй 2 өөр хатууралттай резин толгойтой модон бариултай алх.	<p><b>РЕЗИН АЛХ</b></p>  <p>2 өөр хатууралттай резин толгойтой модон бариултай алх. Толгойн диймшигийн нийт шийдвэртэй 40 мм Үргэлжлэлийн диймшигийн нийт шийдвэртэй 330 мм Жинн: 665 гр</p> <table border="1"> <thead> <tr> <th>Баргуулмын №.</th> <th>Үндэсний түрүүлэлт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>07157210</td> <td>128,700 мянган</td> </tr> </tbody> </table>	Баргуулмын №.	Үндэсний түрүүлэлт	07157210	128,700 мянган												
Баргуулмын №.	Үндэсний түрүүлэлт																				
07157210	128,700 мянган																				
22	Тэмрийн хөрөө	ширхэг	2	Ган сайтай их бие болон хуванцар эсвэл резин бариултай Бариулаараа хөрөөний ирийг чангалдаг мөн дөрвөн өөр өнцөгт байрлуулдаг тохируулгатай	<p><b>Тэмрийн хөрөө</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Маш багийн хуванцар болон хуванцар барилгаатай.</li> <li>Барилгаатай ирвэнийн ирийн контейногт мөн дэргээнд өөр өнцөгт байрлуулдаг тохируулгатай</li> </ul>  <table border="1"> <thead> <tr> <th>Баргуулмын №.</th> <th>Хөрөөний түрүүлэлт</th> <th>Нийт түрүүлэлт</th> <th>Оргил</th> <th>Үндэс</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>0495552892</td> <td>300 мм</td> <td>550 мм</td> <td>140 мм</td> <td>40,425 мянган</td> </tr> </tbody> </table>	Баргуулмын №.	Хөрөөний түрүүлэлт	Нийт түрүүлэлт	Оргил	Үндэс	0495552892	300 мм	550 мм	140 мм	40,425 мянган						
Баргуулмын №.	Хөрөөний түрүүлэлт	Нийт түрүүлэлт	Оргил	Үндэс																	
0495552892	300 мм	550 мм	140 мм	40,425 мянган																	
23	Газов	ширхэг	1	50см-с ихгүй урттай бат бөх ган сайтай газов	<p><b>Газов</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Маш сайн каттуулсан хувь, багийн шударгийн.</li> </ul>  <table border="1"> <thead> <tr> <th>Баргуулмын №.</th> <th>Түрүүлэлт</th> <th>Нийт түрүүлэлт</th> <th>Үндэс</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>61017</td> <td>14"</td> <td>1,7 кт</td> <td>132,000 мянган</td> </tr> <tr> <td>61018</td> <td>18"</td> <td>2,6 кт</td> <td>176,000 мянган</td> </tr> <tr> <td>61019</td> <td>24"</td> <td>4,5 кт</td> <td>275,000 мянган</td> </tr> </tbody> </table>	Баргуулмын №.	Түрүүлэлт	Нийт түрүүлэлт	Үндэс	61017	14"	1,7 кт	132,000 мянган	61018	18"	2,6 кт	176,000 мянган	61019	24"	4,5 кт	275,000 мянган
Баргуулмын №.	Түрүүлэлт	Нийт түрүүлэлт	Үндэс																		
61017	14"	1,7 кт	132,000 мянган																		
61018	18"	2,6 кт	176,000 мянган																		
61019	24"	4,5 кт	275,000 мянган																		
24	Соёнок Жижиг, Том	ширхэг	2	Том болон жижиг хэмжээтэй тус тус 1 ширхэг	<p><b>Соёнок</b></p> <p>F 35000</p> <p>Хуванцарын жижигийн тус тус</p>  <p><b>Хуванцар барилгатай тус тус</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Зүйл бүхий сандаралтуй тусарч соён. Резин оруулгатай хуванцар барилгаатай на гаргаж иштэжин.</li> </ul>  <table border="1"> <thead> <tr> <th>Баргуулмын №.</th> <th>Төмөр түрүүлэлт</th> <th>Түрүүлэлт</th> <th>Оргил</th> <th>Төмөр түрүүлэлт</th> <th>Үндэс</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>0697140</td> <td>25 мм</td> <td>290 мм</td> <td>25 мм</td> <td>130 мм</td> <td>25,410 мянган</td> </tr> </tbody> </table>	Баргуулмын №.	Төмөр түрүүлэлт	Түрүүлэлт	Оргил	Төмөр түрүүлэлт	Үндэс	0697140	25 мм	290 мм	25 мм	130 мм	25,410 мянган				
Баргуулмын №.	Төмөр түрүүлэлт	Түрүүлэлт	Оргил	Төмөр түрүүлэлт	Үндэс																
0697140	25 мм	290 мм	25 мм	130 мм	25,410 мянган																
25	Хуванцар бариултай төмөр сойз	ширхэг	10	Эд анги бохирдолтой хэсгийг цэвэрлэх 3 үе бүхий зэвэрдэггүй төмөр сойз, резин оруулгатай хуванцар бариултай, 40см-с ихгүй урттай, 3см-с ихгүй өргөнтэй	<p><b>Хуванцар барилгатай тус тус</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Зүйл бүхий сандаралтуй тусарч соён. Резин оруулгатай хуванцар барилгаатай на гаргаж иштэжин.</li> </ul>  <table border="1"> <thead> <tr> <th>Баргуулмын №.</th> <th>Төмөр түрүүлэлт</th> <th>Түрүүлэлт</th> <th>Оргил</th> <th>Төмөр түрүүлэлт</th> <th>Үндэс</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>0697140</td> <td>25 мм</td> <td>290 мм</td> <td>25 мм</td> <td>130 мм</td> <td>25,410 мянган</td> </tr> </tbody> </table>	Баргуулмын №.	Төмөр түрүүлэлт	Түрүүлэлт	Оргил	Төмөр түрүүлэлт	Үндэс	0697140	25 мм	290 мм	25 мм	130 мм	25,410 мянган				
Баргуулмын №.	Төмөр түрүүлэлт	Түрүүлэлт	Оргил	Төмөр түрүүлэлт	Үндэс																
0697140	25 мм	290 мм	25 мм	130 мм	25,410 мянган																
26	Эрэг татагч цуглуулга	ширхэг	1	HSS M3-20 хүртэл хэмжээнд эрэг татах 67 ширхэгтэй эрэг татагчийн цуглуулга. Усны хамгаалалттай хуванцар хайрцагтай	<p><b>ЭРЭГ ТАТАГЧИЙН ЦУГЛУУЛГА</b></p>  <p>HSS материалтой. [M3-M20] хүртэл хэмжээнд эрэг татах 67 ширхэгтэй эрэг татагчийн цуглуулга. Багийн хуванцарын хамгаалалттай хуванцар хайрцагтай.</p> <table border="1"> <thead> <tr> <th>Баргуулмын №.</th> <th>Үндэс</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>5964065201</td> <td>2,420,000 мянган</td> </tr> </tbody> </table>	Баргуулмын №.	Үндэс	5964065201	2,420,000 мянган												
Баргуулмын №.	Үндэс																				
5964065201	2,420,000 мянган																				

27	Цоолтуур багц	ширхэг	2	<p>Хатууруулсан хром ванидиум материалтай цохицуур алх зэргийн толгойг элэгдэхээс хамгаалсан байх. Тусгай DIN стандартыг хангасан Shape C 2,3,4,5,6,8 гэх нийт 6 ширхэгтэй</p>	 <p>Хатууруулсан хром ванидиум материалтай Цохицуур/алх зэргийн толгойг элэгдэхээс хамгаалсан тусгай стандартыг DIN 6450 стандартын дагуу Shape C 2,3,4,5,6,8 гэх нийт бүрдэхэнэ.</p> <table border="1" data-bbox="1267 518 1457 563"> <tr> <td>Баргуны №.</td><td>Үндэс</td></tr> <tr> <td>071463 41</td><td>85,800 мтт</td></tr> </table>	Баргуны №.	Үндэс	071463 41	85,800 мтт		
Баргуны №.	Үндэс										
071463 41	85,800 мтт										
28	Цүүц цуглуулга	ширхэг	2	<p>6мм, 10мм, 12мм, 16мм, 20мм, 26мм гэсэн ирний өндөртэй нийт 6 ширхэг цүүцнээс бүрдэнэ.</p>	 <p>6 мм, 10 мм, 12 мм, 16 мм, 20 мм, 26 мм гэсэн ирний өргөнтийг нийт бүрдэхэнэ.</p> <table border="1" data-bbox="1267 804 1457 848"> <tr> <td>Баргуны №.</td><td>Үндэс</td></tr> <tr> <td>0715653001</td><td>440,000 мтт</td></tr> </table>	Баргуны №.	Үндэс	0715653001	440,000 мтт		
Баргуны №.	Үндэс										
0715653001	440,000 мтт										
29	Хуурай Гурвалжин, Дөрвөлжин, Бөөрөнхий	ширхэг	2	<p>300mm-с ихгүй урттай хуванцар бариултай хавтгай, хагас дугуй, дугуй, гурвалжин болон дөрвөлжин хэлбэр бүхий 5 ширхэг төмрийн хуурайны цуглуулга</p>	 <p>Төмрийн хуурайны цуглуулга</p> <ul style="list-style-type: none"> <li>Хуванцар бариултай хавтгай, хагас дугуй, дугуй, гурвалжин бол дөрвөлжин хэлбэр бүхий 5 ширхэг төмрийн хуурайны цуглуулга</li> </ul> <table border="1" data-bbox="1267 1073 1457 1111"> <tr> <td>Баргуны №.</td><td>Үндэс</td><td>Үзэс</td></tr> <tr> <td>071461 90</td><td>200мм</td><td>92,400 мтт</td></tr> </table>	Баргуны №.	Үндэс	Үзэс	071461 90	200мм	92,400 мтт
Баргуны №.	Үндэс	Үзэс									
071461 90	200мм	92,400 мтт									
30	Хусуур	ширхэг	3	<p>Эд анги бохирдолтой хэсгийг цэвэрлэх зориулалттай Резин оруулгатай хуванцар бариултай, 250мм-с ихгүй урттай, сольдог иртэй 6 ширхэгээс багагүй ир дагалдах.</p>	 <p>Хусуур</p> <ul style="list-style-type: none"> <li>Горг шинэ материалын резин болон хуванцар материалын барилгийн.</li> <li>6 ширхэг иртэгээр.</li> <li>Гончирхийн багажийн барилгийн.</li> </ul> <table border="1" data-bbox="1267 1282 1457 1327"> <tr> <td>Баргуны №.</td><td>Үндэс</td></tr> <tr> <td>0714660335</td><td>46,200 мтт</td></tr> </table>	Баргуны №.	Үндэс	0714660335	46,200 мтт		
Баргуны №.	Үндэс										
0714660335	46,200 мтт										
31	1 инчийн импакт буу	Ширхэг	1	<p>6 талт мотортой, чичиргээ бага. Чангалах дээд хүч: 1694 нм-ээс багагүй Суллах дээд хүч: 2440 нм-ээс багагүй Бат бөх, хүчтэй импакт буу</p>	 <p>1 ИНЧИЙН ИМПАКТ БУУ</p> <p>Бат бөх, хүчтэй хийн импакт буу Хүчинтэй хийн импакт буу сийн бүтэц мотортой, чичиргээ бага урчигийн Горг шинэ материалын резин болон хуванцарын барилгийн Хуванцар барилгийн Нийтийн барилгийн Чангалах хүч: 1694 см Суллах дээд хүч: 2440 см Жин: 9,97 кг</p> <table border="1" data-bbox="1267 1641 1457 1686"> <tr> <td>Баргуны №.</td><td>Үндэс</td></tr> <tr> <td>07037780</td><td>3,870,000 мтт</td></tr> </table>	Баргуны №.	Үндэс	07037780	3,870,000 мтт		
Баргуны №.	Үндэс										
07037780	3,870,000 мтт										
32	3/4 Хий буу	Ширхэг	1	<p>6 талт мотортой, чичиргээ бага. Чангалах дээд хүч: 1440 нм-ээс багагүй Суллах дээд хүч: 1500 нм-ээс багагүй Бат бөх, хүчтэй хий импакт буу</p>	 <p>3/4 ИНЧИЙН ИМПАКТ БУУ</p> <p>Бат бөх, хүчтэй хийн импакт буу Хүчинтэй хийн импакт буу сийн бүтэц мотортой, чичиргээ бага урчигийн Хүчинтэй хийн импакт буу сийн бүтэц мотортой, чичиргээ бага урчигийн Чангалах хүч: 1440 см Суллах дээд хүч: 1500 см Жин: 4,73 кг</p> <table border="1" data-bbox="1267 1843 1457 1911"> <tr> <td>Баргуны №.</td><td>Үндэс</td></tr> <tr> <td>07037730</td><td>3,000,000 мтт</td></tr> </table>	Баргуны №.	Үндэс	07037730	3,000,000 мтт		
Баргуны №.	Үндэс										
07037730	3,000,000 мтт										

					<b>3/4 ИНЧИЙН ИМПАКТ БУУ</b>				
33	3/4 инчийн импакт буу	Ширхэг	1	6 талт мотортой, чичиргээ бага. Чангалах дээд хүч: 1440 нм-ээс багагүй Суллах дээд хүч: 1500 нм-ээс багагүй Бат бөх, хүчтэй импакт буу	 <p>Бат бөх, хүчтэй хийн мийдэг буу Хүчиний түүхийнгээ маш сайн б талт мотортой, чиниргүү учир гаргчсан болголтой. Гарг маш эзтэйхиэн хотогдварийн учир хэрэглэхэд маш толгожжэй. Хүчиний төхөрүүлэх тохиургатай. Чангалах дээд хүч: 1440 нм Суллах дээд хүч: 1500 нм Жин: 4,73 кг</p> <table border="1"> <tr> <td>Баргуны №:</td> <td>Үндэс</td> </tr> <tr> <td>07037730</td> <td>1,012,000 мтн</td> </tr> </table>	Баргуны №:	Үндэс	07037730	1,012,000 мтн
Баргуны №:	Үндэс								
07037730	1,012,000 мтн								
34	Батарей дрилл	Ширхэг	1	2 араа, 2 өөр хурд болон хүчтэй, мотор хамгаалагчтай 1 болон 2 арааны хурд: 0-400/0-1500 (грт)-ээс багагүй 1 болон 2 арааны хүч: 32/19 Нм-ээс багагүй Хошууны хавчих диаметр: 0.8-10мм Батерия: 12V/DC 2x260 Ah Эсхүл түүнтэй дүйцэх.	 <p><b>AWS 12 COMPACT BATTERIE DRILL</b></p> <p>Жижиги болоч хүч сайтай. 2 өөр хурд болон хүчтэй 2 орлогийн, LED гарзгийт. Жижиг болоч хүчин чадал нийтийн - нийн батарейийн. Моторын хурд: 1 болон 2 орлон хүч: 0-400 / 0-1500 (грт) 1 болон 2 орлон хүч: 32 / 19 Нм Хошууны хавчих диаметр: 0.8-10 мм Жин: 1,21 кг Батарей: 12V/DC 2 x 2.0 Ah</p> <table border="1"> <tr> <td>Баргуны №:</td> <td>Үндэс</td> </tr> <tr> <td>5701101002</td> <td>\$23,000 мтн</td> </tr> </table>	Баргуны №:	Үндэс	5701101002	\$23,000 мтн
Баргуны №:	Үндэс								
5701101002	\$23,000 мтн								
35	Батарей тастагч	Ширхэг	1	Шойтолгүй мотортой байх. Таслагч ир гацсан үед автоматаар унтардаг байх. Мотор хэт ачаалсан үед гэрлээр эсвэл дуут дохио өгдөг. Ли-ион батарейтай эсхүл түүнтэй дүйцэх, батарейн цэнэгийг харуулах индикатортой байх. Унтраах үед иш түргэн зогсоно. Вольт:18V/DC-ээс багагүй. Эргэлтийн хурд: 10000грт-ээс багагүй Таслагч ирний диаметр: 125мм	 <p><b>AWS 18-125 P BATTERIE TASLAGH</b></p> <p>Шойтолгүй мотортой. Таслагч ир гацсан үед автоматаар унтардаг. Мотор хэт ачаалсан үед гарзлээр дюнжээ илнэ. Жижиг болоч хүчин болоч хүч маш сайн. Ли-ион батарейтай. Батарейн цэнэгийг харуулах индикатортой. Deodion's switch буюу унтраах үед иш хурдан зогсоно. Вольт: 18V/DC Эргэлтийн хурд: 10000 грт Таслагч ирний диаметр: 125 мм Жин: 1,65 кг</p> <table border="1"> <tr> <td>Баргуны №:</td> <td>Үндэс</td> </tr> <tr> <td>5701402005</td> <td>2,024,000 мтн</td> </tr> </table>	Баргуны №:	Үндэс	5701402005	2,024,000 мтн
Баргуны №:	Үндэс								
5701402005	2,024,000 мтн								
36	Цахилгаан дрилл	Ширхэг	2	Цахилгаан гар дрилл. Моторын хүч: 600 Ватт-аас багагүй Эргэлтийн хурд: 0-2600 (грт)-аас багагүй Кабелын урт: 4 метрээс багагүй. Дээд хүч: 20 Нм-аас багагүй	 <p><b>GAR DRILL SB 10-E COMPACT</b></p> <p>Мод. нийн шилжин, тиймчүй болгон бусад мөнгөддөй харалтадаа Гарг заталын жижиг хамгийн жижиг болоч хүч маш сайн. Цахилгааны хобийн урт: 4 метр Моторын хурд: 0-2600 грт Эргэлтийн хурд: 0-2600 (грт) Дээд хүч: 20 Нм Нийт жин: 1,7 кг</p> <table border="1"> <tr> <td>Баргуны №:</td> <td>Үндэс</td> </tr> <tr> <td>07023270</td> <td>\$20,000 мтн</td> </tr> </table>	Баргуны №:	Үндэс	07023270	\$20,000 мтн
Баргуны №:	Үндэс								
07023270	\$20,000 мтн								



42	Шингэн тос болон түлшний гар насос	Ширхэг	2	<p>Техникт шингэн тос болон түлш нэмэхэд ашиглана.</p> <p>Модель - LP-32</p> <p>Сорох / шахах диаметр /мм/ - 32 / 25-с багагүй</p> <p>Хүчин чадал (л/мин) - 100-аас багагүй</p> <p>Гарах хоолойн урт - 956мм-ээс багагүй</p> <p>Овор хэмжээ - 1127x242x280мм</p> <p>Жин - 6,7кг-с багагүй байх.</p>	 <p>Home   Засвар Автомат ШИНГЭН ТОС БО НАСОС KOSHIN L Үнэ: 550,000₮ Тос болон түлшний насос Дулгозын Баруун код: 11-0006 Английн: Pumping Unit Шоот: Улаанбаатар Facebook   YouTube   Instagram</p>										
43	Тосны сав Жижиг 65 литртэй	Ширхэг	2	<p>Техник үйлчилгээнээс гарсан сольсон тос масло тосох сав.</p> <p>Багтаамж: 65 литр-ээс багагүй.</p> <p>Материал: полиэтилен гранули эсхүл түүнтэй дүйцэх</p> <p>Өнгө: хар болон бараан төрлийн өнгө</p>	<p><b>ХУВАНЦАР ХУВИН</b></p>  <p>Материал - полиэтилен Өнгө - хар Хэлбэр - дугуй</p> <table border="1"> <thead> <tr> <th>Баруун №.</th> <th>Хэлбэр</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>0993997025</td> <td>Дугуй</td> </tr> <tr> <td>0993997021</td> <td>Дүгүү</td> </tr> <tr> <td>0993997022</td> <td>Персиктэйн</td> </tr> <tr> <td>0993997023</td> <td>Ларантай</td> </tr> </tbody> </table>	Баруун №.	Хэлбэр	0993997025	Дугуй	0993997021	Дүгүү	0993997022	Персиктэйн	0993997023	Ларантай
Баруун №.	Хэлбэр														
0993997025	Дугуй														
0993997021	Дүгүү														
0993997022	Персиктэйн														
0993997023	Ларантай														
44	Тосны сав Том 90 литртэй	Ширхэг	2	<p>Техник үйлчилгээнээс гарсан сольсон тос масло тосох сав.</p> <p>Багтаамж: 90 литр-ээс багагүй.</p> <p>Материал: полиэтилен гранули эсхүл түүнтэй дүйцэх</p> <p>Өнгө: хар болон бараан төрлийн өнгө</p>	<p><b>ХУВАНЦАР ХУВИН</b></p>  <p>Материал - полиэтилен Өнгө - хар Хэлбэр - дугуй</p> <table border="1"> <thead> <tr> <th>Баруун №.</th> <th>Хэлбэр</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>0993997025</td> <td>Дугуй</td> </tr> <tr> <td>0993997021</td> <td>Дүгүү</td> </tr> <tr> <td>0993997022</td> <td>Персиктэйн</td> </tr> <tr> <td>0993997023</td> <td>Ларантай</td> </tr> </tbody> </table>	Баруун №.	Хэлбэр	0993997025	Дугуй	0993997021	Дүгүү	0993997022	Персиктэйн	0993997023	Ларантай
Баруун №.	Хэлбэр														
0993997025	Дугуй														
0993997021	Дүгүү														
0993997022	Персиктэйн														
0993997023	Ларантай														

## БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	[Барааны нэрийг бичих]	[Нэгжийн тоо ширхгийг бичих]	[Хэмжих нэгжийг бичих]	[Бараа хүргэх газрын нэр]	[Гэрээ байгуулснаас хойш нийлүүлэх хугацаа бич. Жишээ нь: 2024.01.01-ээс 2024.02.01]	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]
1	Багц1. Аж ахуйн бараа материал, багаж хэрэгсэл	Техникийн тодорхойл олтод заасан тоо хэмжээний дагуу	Техникийн тодорхойл олтод заасан тоо хэмжээний дагуу	Баянгол дүүргийн 20-р хороо Сонголон дахь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төв агуулах.	Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш хуанлийн 45 хоногийн дотор нийлүүлнэ.	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]
2	Багц2. Засварын багаж хэрэгсэл					

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ  
Захиалагч энэ бүлэгт оролцогчийн бөглөх шаардлагатай бүх маягтыг тусгана.

**Маягтын жагсаалт:**

<b>Маягт 1: Тендер илгээх маягт.....</b>	<b>28</b>
<b>Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл.....</b>	<b>29</b>
<b>Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл .....</b>	<b>29</b>
<b>Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл .....</b>	<b>29</b>
<b>Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт .....</b>	<b>29</b>

## Маягт 1: Тендер илгээх маягт

[огноо]

### [Захиалагч байгууллагын нэр]

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
  - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
  - 2.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
  - 3.1. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
  - 4.1. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна<sup>1</sup>
5. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын догодолгүй болохыг баталж байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**Баталгаажуулсан: Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг мэдээлэл:**

**Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

**Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

Оролцгчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

**Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

**Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

## V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь захиалагч, гүйцэтгэгч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно.

Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох бараа худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол ГТН-ийн холбогдох заалтад тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан өөрчлөлт оруулан ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөхгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохиорох үг өгүүлбэр, too хэмжээ зэрэгт нийцүүлэн тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР</b>	
<b>Тодорхойлолт</b>	<p>1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:</p> <p>1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;</p> <p>1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;</p> <p>1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;</p> <p>1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;</p> <p>1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;</p> <p>1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;</p> <p>1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.</p> <p>1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;</p> <p>1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;</p> <p>1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;</p> <p>1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;</p> <p>1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны</p>

	үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориотой өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
<b>Гэрээний тайлбар</b>	<p>1.2.Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:</p> <p>1.2.1.Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.</p> <p>1.2.2.Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.</p> <p>1.2.3.Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлахад бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.</p> <p>1.2.4.Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.</p> <p>1.2.5.Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.</p>
<b>ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ</b>	
<b>Бараа нийлүүлэх</b>	<p>2.1.Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй</p> <p>2.2.Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна</p> <p>2.3.ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.</p> <p>2.4.Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.</p>
<b>Бараа нийлүүлэх газар</b>	2.5.Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
<b>Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах</b>	<p>2.6.Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.</p> <p>2.7.Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <p>2.7.1.Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</p> <p>2.7.2.Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.</p> <p>2.8.Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>2.9.ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.</p>
<b>Барааг хүлээлгэн өгөх</b>	2.10.Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

	2.11. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
<b>Барааны гарал үүслийн улс</b>	2.12. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна. 2.13. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
<b>Баглаа боодол</b>	2.14. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хийнэ. 2.15. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа бооддолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно. 2.16. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
<b>Худалдааны нөхцөл</b>	2.17. Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана. 2.18. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
<b>ГУРАВ. ЗАХИАЛАГЧ</b>	
<b>Барааг хүлээн авах</b>	3.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
<b>Шалгалт, туршилт</b>	3.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
	3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ. 3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна. 3.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй. 3.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.
<b>Гэрээний үнэ</b>	3.7. Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана. 3.8. Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.
<b>Төлбөр төлөх</b>	3.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.

	<p>3.10. Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>3.11. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>3.12. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.</p> <p>3.13. ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> <p>3.14. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>3.15. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p>
<b>ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА</b>	
<b>Захиалагчийн хүлээх эрсдэл</b>	<p>4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</p> <p>4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.</p>
<b>Даатгал</b>	<p>4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.</p>
<b>Доголдол</b>	<p>4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.</p>
	<p>4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.</p>
	<p>4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.</p>
	<p>4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.</p>
	<p>4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.</p>
	<p>4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p>
	<p>4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p>
<b>Чанарын баталгаа</b>	<p>4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.</p>

	<p>4.11.ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.</p> <p>4.12.Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>4.13.ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>4.14.Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнэ.</p> <p>4.15.ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16.ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p>
<b>Алданги</b>	<p>4.17.Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнэ.</p> <p>4.18.Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнэ.</p>
<b>Оюуны өмчийн эрх зөрчих</b>	<p>4.19.Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p>
<b>Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал</b>	<p>4.20.Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>4.21.Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p>
	<p>4.22.Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>4.23.Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.</p>
<b>Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа</b>	<p>4.24.Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>4.25.Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p>
<b>ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ</b>	

<b>Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл</b>	<p>5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:</p> <p>5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;</p> <p>5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;</p> <p>5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.</p> <p>5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.</p> <p>5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.</p> <p>5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.</p>
<b>Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл</b>	5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээ дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.
<b>ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ</b>	
<b>Төлөөлөгч</b>	<p>6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.</p> <p>6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p>
<b>Туслан гүйцэтгэгч</b>	<p>6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илуу хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.</p>
<b>Нууцлал</b>	<p>6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусдад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p>

<b>Мэдэгдэл</b>	<p>6.9.Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>6.10.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.11.Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>6.12.Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <ul style="list-style-type: none"> <li>6.12.1.баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;</li> <li>6.12.2.биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.</li> </ul> <p>6.13.Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>6.14.ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p>
<b>Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах</b>	<p>6.15.Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>6.15.1.ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;</li> <li>6.15.2.үнийн тохируулга хийсэн.</li> </ul>
	<p>6.16.Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.</p> <p>6.17.ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.</p>
<b>Маргаан шийдвэрлэх</b>	<p>6.18.Гэрээг биелүүлэхтэй холбогdon гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p>
	<p>6.19.Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p>

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<b>ГЕН 2.5.</b>	Бараа нийлүүлэх газар: <b>Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хороо Сонсголонд байрлах "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн төв агуулах</b>
<b>ГЕН 2.6.</b>	Бараа нийлүүлэх хугацаа: <b>Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 45 хоногийн дотор нийлүүлнэ.</b>
<b>ГЕН 2.10.</b>	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: Барааг хүргэж өгөх болон холбогдох бүх зардлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.
<b>ГЕН 2.14.</b>	Баглаа, боодол: <b>Тээвэрлэхэд тохиromжтой, ус чийг, гаднын нэлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын саё, баглаа боодолтой байна.</b>
<b>ГЕН 2.16</b>	Баглаа боодол түүний дотор гадна талд тэмдэглэгээ хийх: " <b>Үгүй</b> "
<b>ГЕН 2.17.</b>	Худалдааны нөхцөл: <b>Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: "Тийм" Incoterms 2020, DDP нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлнэ.</b>
<b>ГЕН 3.8.</b>	Үнийн тохируулга хийх аргачлал: <b>Үнийн тохируулга хийхгүй тогтмол байна.</b>
<b>ГЕН 3.9.</b>	Төлбөр төлөх хугацаа: <b>Захиалагч нь нийлүүлэгч талд урьдчилгаа төлбөр олгохгүй бөгөөд төлбөрийг бараа бүрэн нийлүүлэгдсэний дараа захиалагч болон нийлүүлэгчийн хооронд үйлдсэн гэрээ дүгнэсэн акт, нэхэмжлэх, зарлагын баримт болон холбогдох бичиг баримтыг үндэслэн төлбөрийн нэхэмжлэх хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор нийлүүлэгч байгууллагын дансанд бэлэн бусаар шилжүүлнэ.</b>
<b>ГЕН 4.2.</b>	Даатгал: <b>Нийлүүлэгчээс захиалагчид хүргэж хүлээлгэн өгөх хуртэлх зохих бүх даатгалыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.</b>
<b>ГЕН 4.10.</b>	Баталгаат хугацаа:
<b>ГЕН 4.11</b>	Чанарын баталгаа шаардах эсэх: " <b>Үгүй</b> "
<b>ГЕН 4.17.</b>	Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: " <b>Тийм</b> " Алдангийн хувь: Гэрээний үүргээ биелүүлээгүй хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,01% Алдангийн нийт дүн: Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй.
<b>ГЕН 4.18.</b>	Захиалагчийн төлөх алданги: Алданги тооцох эсэх: " <b>Тийм</b> " Алдангийн хувь: Гэрээний үүргээ биелүүлээгүй хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,01% Алдангийн нийт дүн: Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй.

**ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ**  
[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Техникийн тодорхойлолт;
  - 3.6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:
  - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 07 дугаар сарын 30-ны өдөр**  
Тендер шалгаруулалтын төрөл: **Бараа**  
Тендер шалгаруулалтын нэр: **Аж ахуйн болон засварын багаж хэрэгсэл нийлүүлэгчийг сонгох**  
Тендер шалгаруулалтын дугаар: **ЭТТХК/20240202414**  
Нийт төсөвт өртөг: **48,494,983 /дөчин найман сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга есөн зуун наян гурав/төгрөг**  
Тендер шалгаруулалтын арга: **Харьцуулалт**

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ:

**Багц 1: Аж ахуйн бараа материал, багаж хэрэгсэл**

**Багц 1: Засварын багаж хэрэгсэл**

Дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах бараа бол тодорхой бичих: “Үгүй”

3. Үнийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: **1**

4. Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам:

5. Үнийн санал дуудах ажиллагааг **2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 09 цаг 10 минутаас** эхлүүлж, **2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 11 цаг 20 минутын** хугацаанд зохион байгуулна.

6. Тендерийг **2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн, 09 цаг 00 минутаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн, 09 цаг 10 минутад** нээнэ.

7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: “Зөвшөөрөхгүй”

8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: “Эрхгүй”

9. Тендер нь түүнийг нээнээс хойш ажлын 30 ба түнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.

10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын-8,

Финанс төв, 5-р давхар, 504 тоот,

Утас: 75055555 дотуур утас-504.